



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 5/02

Улаанбаатар хот

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2013 ОНЫ ЗОРИЛТЫГ
БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.а заалтыг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит тавдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Баянгол дүүргийн Эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийн тайланг хагас, бүтэн жилээр гарган дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байхыг дүүргийн Засаг дарга /Д.Оросоо/-д даалгасугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРБАТ



Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2013 оны 3 дугаар тогтоолын хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2013 ОНЫ ЗОРИЛТ

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2013-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗААЛТ	2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХУГАЦАА	ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА
НЭГ. АГААР ЦЭВЭР ДҮҮРЭГ			
1.1 Баянгол дүүрэгт агаарын бохирдлыг бууруулах нэгдсэн төлөвлөгөөг Засгийн газрын болон Нийслэлийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нийцүүлэн батлан хэрэгжүүлж агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг авна.	Дүүргийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах нэгдсэн хөтөлбөрийг боловсруулан батлуулна.	1-4 улирал	ЗХХ
	Нэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, биелэлтийг хангуулна.	2-4 улирал	ДБТХ, ХЗД, ХҮҮХ, ЭЗТХ
1.2 Дүүргийн гэр хороолол бүхий хороодыг дахин төлөвлөлт хийх замаар төвлөрсөн болон бие даасан эрчим хүчний эх үүсвэрт хэсэгчлэн холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Дахин төлөвлөлт хийх замаар 20 дугаар хорооны Мах маркетийн хойд талын халаалтын зуухаар халдаг хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжинд холбох ажлыг эхлүүлнэ.	3-4 улирал	ДБТХ, МХХ, ӨГХХ, ХААХ, ЭЗТХ
1.3 Дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачлагад тулгуурлан нийтийн эзэмшлийн зам талбайг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх, мод тарих замаар ногоон байгууламжийг 25 хувиар нэмэгдүүлнэ.	Дүүргийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг иргэдийн бүлгүүдэд хариуцуулж урамшууллын тогтолцоог бүрдүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	3-4 улирал	ДБТХ, ХЗД
	Өөрийн хөрөнгөөр мод, бут сөөг тарьж, арчладаг иргэдэд үзүүлэх урамшууллыг үргэлжлүүлэн олгоно.	3-4 улирал	ДБТХ, ЭЗТХ, ХЗД
	Дүүргийн ЗДТГ-т ногоон байгууламж, экологи, мод, ургамлын мэргэшсэн мэргэжилтэнтэй болж иргэд байгууллагуудад сургалт, арга зүйн зөвлөгөө өгнө.	3-4 улирал	ЗХХ, Тамгын дарга
	Цэцэрлэгжилт, тохижилтгүй талбай бүхий албан байгууллага, аж ахуй нэгжийн газар ашиглалтын төлбөрийг цэцэрлэгжүүлсэн талбайн хэмжээнээс хамаарч газар ашиглалтын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тогтолцоог нэвтрүүлнэ.	3-4 улирал	ДБТХ, ЗХХ, ӨГХХ,
1.4 Дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Цэцэрлэгт хүрээлэн" байгуулж иргэдийн амралт зугаалгын бүс бий болгоно.	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах эрх зүйн орчныг нь бүрдүүлж, ажлын зургийг гаргаж, газрын нөхөн сэргээлтийн ажлыг хийнэ.	1-2 улирал	ЗХХ, ӨГХХ
	Цэцэрлэгт хүрээлэн байгуулахад олон нийтийн анхаарлыг хандуулан, үүрэг оролцоог нь нэмэгдүүлж, дүүргийн бүх хороодод нэрэмжит хэсгүүдийг бий болгон хамтран ажиллана.	2-4 улирал	ДБТХ, ХЗД
1.5 Зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалтын тогтолцоог иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоотойгоор бий	Дүүргийн "эко цагдаа" ажиллуулах журам боловсруулж, ажил үүргийн хуваарийг нарийн тусгаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.	2-3 улирал	ЗХХ, ХЗД